# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

“ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:** САГ-2019/118/СТА-ТӨХК

**Агуулга**


1 Аудитын гэрчилгээ ..... 2
2 Аудитын тайлан ..... 4
2.1. Оршил ..... 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл ..... 7
2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал. ..... 7
2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10
2.10. Үйл ажиллагааны орлого, зорилтот түвшний хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 10
2.11. Шилэн дансны мэдээлэл ..... 10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 11
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 11
3 Менежментийн захидал ..... 12
3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал ..... 12
3.2 Үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал ..... 12
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 17
5 Аудитын явцад илэрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 23


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТЗБАХ | Техник зохион байгуулалтын арга хэмжээ |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/488
танай ____________-ны № ____________-т

"ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЦОГОО ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2019\0315SAG50.Docx

071259

**Аудитын гол асуудал**

Мөрөн сумын орон нутгийн төсвийн 32 байгууллагад хүчингүй болсон тарифаар дулаан нийлүүлэх гэрээ хийж, нийт 977.9 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан, энэ үйл ажиллагаатай холбоотой 659.5 сая төгрөгийн хэрэгжээгүй борлуулалт, авлагыг нөхөн бүртгэсэн, 177.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 69.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө өөр байгууллагад давхар бүртгэлтэй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Үүрэг, хариуцлага**

“Хөвсгөл дулааны станц" ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

УХА#122

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2019\0315SAG50.Docx

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Цогоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 3 дугаар сарын 15–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал хянан удирдаж, чанарын хяналтын менежер Р.Цанжидмаа хяналт тавьж, аудитор Д.Солонго, А.Мөнхцоож нарын бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж хэрэгжүүлэв.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 93 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч төсвийн тухай хуульд заасан цагалбар хугацааг 7 хоногоор хожимдуулсан байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК нь "Дэвшилтэт технологид суурилсан үр ашигтай, хэмнэлттэй дулааны эрчим хүчийг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийлүүлэн найдвартай хүргэнэ" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн дүрэмд компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалттай хангах

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Цахим гарын үсгийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- Татварын багц хууль

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС)
- Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар, 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, Монгол Улсын Засгийн газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан тогтоол, тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт өөрчлөлт гаргаагүй ба Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлтөд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 18 дугаар тогтоолоор компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 32,380,792 ширхэг энгийн хувьцааны 70 хувь буюу 22,666,504 ширхэг хувьцааг Эрчим хүчний яам, 30 хувь буюу 9,714,238 ширхэг хувьцааг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмших болсон байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулсан боловч баталж мөрдөөгүй, уг төсөл нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомж, салбарын зохицуулах байгууллагаас баталсан журам, аргачлалтай нийцээгүй байна.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК нь дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан тогтоол, тушаал, дүрэм, журам, заавар, аргачлалыг мөрдөж ажиллах шаардлагатай.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Интерактив Би Ай" ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн "Diamond 5.0” програм хангамж ашигладаг байна.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөгүй” гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус компани төрийн өмчит хувьцаат компани бөгөөд улсын төсөвт орлого төвлөрүүлдэг, нийт зардал нь тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал нь 5,327.2 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 106.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 13 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

#### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Тус компани нь 0.6 сая төгрөгийн бараа материалын орлогыг бүртгээгүй, зарлага гаргаж, хасах үлдэгдэл тайлагнасан байна.

Энэ нь “хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, оршин байх” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4.-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Уг алдаа зөрчлийг аудитын явцад залруулан, санхүүгийн тайланд тусгаж, тайлагнасан.

#### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулагдаагүй 13 алдаа зөрчилтэй асуудлыг дансны ангилал, агуулгаар нь нэгтгэж, 6 зөвлөмж, 1 акт, 2 албан шаардлага тогтоосон.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 6 | 118.4 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 1.6 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 2 | 1,186.8 | |
| | **Дүн** | **9** | **1,306.8** | |

**2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.2.1.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн, 2017 оны 9 дүгээр сарын 15-наас мөрдөхөөр баталсан байна. Гэтэл гүйцэтгэх захирал Хөвсгөл аймгийн Засаг даргын орлогчтой байгуулсан “Хөвсгөл аймгийн Мөрөн сум дахь төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдэд дулааны эрчим хүч нийлүүлэх ажлын” ХӨ-2018/8.811 дугаар гэрээгээр орон нутгийн төсвөөс санхүүжигч 32 төсөвт байгууллагад 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд дээрх тогтоолоор хүчингүй болгосон тарифаар борлуулах гэрээ хийж мөрдсөн нь нийт 977.9 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна. Энэ үйл ажиллагаатай холбогдуулж дээрх төсөвт байгууллагуудаас 659.5 сая төгрөгийн хэрэгжээгүй борлуулалт, авлагыг нөхөн бүртгэсэн нь тайлант оны борлуулалтыг өсгөж, борлуулалтад ногдох 60.0 сая төгрөгөөр НӨАТ-ын өглөгийг нэмэгдүүлж, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь “үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх” 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

**2.8.2.1.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа**

Дулаан-Орд ХХК, “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-д ажлын байрны зориулалтаар ус, дулаан дамжуулах төв түрээслүүлэх 2018 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 18/19 дүгээр гэрээ хийж, түрээслэгч тус төвөөр дамжуулан борлуулсан дулааны орлогын 70.0 хувь, дулаан дамжуулах төвд гарсан зардал, төвийн нэг ажилтаны цалин 0.4 сая төгрөгийг сар бүр түрээслүүлэгчид төлнө гэж илт нэг талын эрх ашигийг хангасан гэрээ байгуулсан

Энэ нь “үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ

байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

**2.8.2.1.3 Өглөгтэй холбоотой асуудал**

Байгууллагын өглөгийн үлдэгдэл, тооцоо нийлж баталгаажуулсан байдлыг хянаж үзэхэд харилцагч 9 байгууллагатай 138.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, актаар баталгаажсан "Абдикс" ХХК-ийн өглөгийг 1.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь “үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6.-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

**2.8.2.1.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

“Хөвсгөл аймгийн Дулааны станцын ашиглалтын өмнөх захиргаа”-ны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 34.8 мВт-ын хүчин чадалтай дулааны станцад холбогдох 7,966.3 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг “Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах улсын комисс”-ын 2016 оны 49/2015 тоот актаар “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-д хүлээлгэн өгсөн байна. Гэтэл уг хөрөнгөнд бүртгэлтэй 4 нэр төрлийн 69.5 сая төгрөгийн хөрөнгө “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн дансанд давхар бүртгэлтэй байна.

Энэ нь “үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*”, 5.1.3-д “*жинхэнэ хэрэгжилтийн*”, 5.1.4-д “*үнэн зөв байх*” 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.Энэ нь “үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6.-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

**2.8.2.1.5 Дотоод хяналт**

Компанийн өмнөх гүйцэтгэх захирал ТУЗ болон ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр өөртөө 1.4 сая төгрөгийн урамшуулал олгож, 0.2 сая төгрөгийн ажил олгогчийн НДШ төлсөн байна.

Энэ нь “үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт” зэрэг батламж мэдэгдэл, Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6-д “Энэ хуулийн 81.2-т заасан цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна”, 81.6.2-д “төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл

ажиллагаа явуулахыг хориглоно”, "Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн ТУЗ-өөс гүйцэтгэх захиралтай байгуулсан контракт-ын 4.2-т "Гүйцэтгэх захиралд компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийг харгалзан холбогдох журмын дагуу урамшуулал олгох эсэх асуудлыг ТӨБЗГ эцэслэн шийдвэрлэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 онд хийх техник зохион байгуулалтын арга хэмжээнд 215.0 сая төгрөгийн 7 ажил хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 153.8 сая төгрөгийн 4 ажил, хөрөнгө оруулалтаар 1,005.7 сая төгрөгийн 39 ажил хийхээс, 128.1 сая төгрөгийн 13 ажил хийгдэж, төлөвлөгөөний биелэлт 22.5 хувьтай байна. Энэ нь өөрийн хөрөнгийн эх үүсвэр хүрэлцэхгүйгээс шалтгаалсан байна.

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хөрөнгийн үнэлгээний "Уваа уул аудит" ХХК-аар хийлгэж, 091100145 дугаар бүхий тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчин Б.Эрдэнэсүрэн нягтлан шалгасан байна. Дахин үнэлгээгээр 33 барилга байгууламжийн 3,155.7 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 462.5 сая төгрөгийн 2 газрыг шинээр бүртгэж тайлагнасан байна.

**2.10. Үйл ажиллагааны орлого, зорилтот түвшний хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 422 дугаар тогтоолоор “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн “2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, 2018 онд өөрийн хөрөнгөөр хийх техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

Тус зорилтот түвшний төлөвлөгөөгөөр компани 2018 онд нийт 61,000 Гкал дулаан үйлдвэрлэж, 4,991.1 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 73,425.2 Гкал дулаан үйлдвэрлэн, 5,115.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, дулаан үйлдвэрлэлийг 20.4 хувиар буюу 12,425.2 Гкал-аар, орлогыг 2.5 хувиар буюу 123.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогыг задалж үзвэл байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 5,077.4 сая, бусад орлого 37.6 сая, нийт 5,115.0 сая төгрөгийн орлоготой байна.

Зардлын нийт гүйцэтгэл 5,327.2 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 4.6 хувь буюу 236.7 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Тухайлбал: нүүрсний зардал 23.8 сая, нүүрс тээврийн зардал 95.8 сая, урсгал засварын зардал 60.7 сая, элэгдлийн зардал 20.0 сая, түрээсийн зардал 11.8 сая, бусад зардал 17.6 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн өмчит хувьцаат компани нь 6 дугаар зүйлд заасан 7 төрлийн мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх мэдээллийг шалгаж үзэхэд хуульд заасан хугацаанд жил улирал, сар, тухай бүр оруулах 7 төрөлд хамаарах нийт 62 удаагийн мэдээлэл оруулахаас тайлант хугацаанд 51 мэдээг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хожимдуулж www.shilendans.gov.mn сайтад байршуулж, толилуулсан байна.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Кассын зарлагын баримтад мөнгө хүлээн авагчийн гарын үсэггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ бүртгэсэн.

Энэ нь “үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4.-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан тэнцэл буруу гарах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 дүгээр заалтыг мөрдөж, ажил гүйлгээ бүрээр анхан шатны баримтыг бүрдүүлж, бүртгэж тайлагнах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

### 3.2 Үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:
   - Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын чанартай зүйлс, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн чанартай зүйлсийг бүртгэж тайлагнасан
   - Дуусаагүй барилгыг бараа материалд бүртгэж тайлагнасан

Энэ нь “толилуулга ба тодруулга, үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдэл, НББОУС 2 Бараа материал, НББОУС 16 Үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2. Тус байгууллагын гүйцэтгэх захирлын 2018 оны 9 дүгээр сарын А/91 дугаар тушаалаар хийсэн хяналтын тооллогоор санхүүгийн тайланд бүртгэлтэй, биетээр байхгүй 211.4 сая төгрөгийн бараа материал дутагдаж, ашиглалтын шаардлага хангахгүй 850.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө илэрсэн нь компани байгуулагдснаас хойших 4 жилийн хугацаанд хөрөнгийн тооллого, тооцоо бодолтыг чанартай хийгээгүйтэй холбоотой байна.

Энэ нь “оршин байх, хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал, иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “Жинхэнэ хэрэгжилтын зарчим, 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-д “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3. "Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн өмчлөлд байгаа үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоог хянаж үзэхэд Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ыг мөрдөөгүй буюу 69 барилга байгууламж, 12 тавилга эд хогшил, 26 машин, тоног төхөөрөмж, 7 тээврийн хэрэгсэл, 40 компьютер дагалдах хэрэгслийн ашиглах хугацааг 1-55 жилийн зөрүүтэй тооцсон байна.

Энэ нь “хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал” зэрэг батламж мэдэгдэл, НББОУС 16, НББОУС 12, Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”, Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам” зэрэгтэй нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан тэнцэл буруу гарах
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах
- Хөрөнгө үрэгдэж, шамшигдах

3.2.3. Өгсөн зөвлөмж

- Бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгүүдийг СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнах
- Хөрөнгийн тооллого тооцоог чанартай хийж, үр дүнг хэлэлцэн, гарсан зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авч ажиллах
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолыг мөрдөж, санхүүгийн програмд өөрчлөлт оруулан элэгдлийг үнэн зөв бүртгэж тайлагнаж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

**3.3 Эздийн өмчтэй холбоотой асуудал**

3.3.1. Илрүүлэлт

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 206 дугаар тогтоолоор “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийг байгуулсан байна. Төрийн өмч санхүүгийн тайланд 33,981.5 сая, улсын бүртгэлийн гэрчилгээнд 26,008.2 сая, компанийн дүрэмд 32,380.8 сая төгрөг гэж тус тус зөрүүтэй байна.

Энэ нь “үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ” зэрэг батламж мэдэгдэл, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дугаар зүйлийн 14.2-т “Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан тэнцэл буруу гарах
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах

3.3.3. Өгсөн зөвлөмж

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтүүдийг хуулийн хугацаанд бүртгүүлж, санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

**3.4 Худалдан авалттай холбоотой асуудал**

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан нүүрс, шатах тослох материал, тэдгээрийн татварын цахим системд бүртгэсэн байдал, НӨАТ-ын болон, санхүүгийн бүртгэл, тайлагналыг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

Тайлант оны нүүрс, шатах тослох материалын худалдан авалт, тээвэрийн хөлсний төлөлтөөр нийлүүлэгч байгууллагуудаас татварын цахим системд тус байгууллагын нэр дээр борлуулалтыг илүү шивснээс үндэслэлгүйгээр 9,465.8 мянган төгрөгөөр НӨАТ-аас хасалт хийсэн, дутуу шивснээс 61,056.6 мянган төгрөгөөр НӨАТ-ын өглөгөөс хасалт хийх боломжыг алдсан.

Эдгээр нь “хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсвэл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэн”, 14.4-д “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг баталгаажуулсан нэмэгдсэн өртгийн албан татварын падааныг үндэслэн албан татварын хасалтыг хийнэ”, 14.5-д “Албан татвар суутган төлөгч нь бэлтгэн нийлүүлэгчид албан татвар төлсөн нь нэхэмжлэл, нэмэгдсэн өртгийн албан татварын падаан, нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг албан татварыг хасаж тооцохгүй” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх

- Татварын хүү торгууль хүлээх
- Үндэслэлгүйгээр татварын өглөг өсөх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж, худалдан авалт бүрд и-баримт авч хэвших

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

**3.5. Зардалтай холбоотой асуудал**

3.5.1. Илрүүлэлт

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулсан нүүрсний зарцуулалт инженерийн албаны тооцоогоор 24,238.0 тн, эдийн засагчийн тооцоогоор 24,140.0 тн, санхүүгийн тайлангаар 24,250.0 тн гэж тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь “үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ, оршин байх” зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулах зөвлөлийн 2006 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Дулааны цахилгаан станцын техник, эдийн засгийн аргачилсан заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.5.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан тэнцэл буруу гарах
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах
- Дотоод хяналт сулаас хөрөнгө үрэгдэх

3.5.3. Өгсөн зөвлөмж

Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулах зөвлөлийн 2006 оны 128 дугаар тогтоолыг мөрдөж, нүүрсний зарцуулалтыг үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

**3.6. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

3.6.1. Илрүүлэлт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад тууштай мөрдөгдөх тухайн байгууллагын баталсан зүй тогтол болон тогтсон дэг журмын суурь юм. Тус байгууллага нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь “хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал, иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.6.2. Эрсдэл

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан тэнцэл буруу гарах
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах

3.6.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг СТОУС, түүнд нийцүүлэн баталсан заавар журмын дагуу боловсруулж, мөрдөж ажиллах.

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2017 оны 12 сарын 1 | 2018 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 20,717,367.28 | 21,779,327.02 |
| 1.1.2 | Дансны авлага | 157,146,540.03 | 774,310,633.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 138,085.70 | 138,085.70 |
| 1.1.6 | Бараа материал | 765,121,131.63 | 549,979,335.00 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 197,607,897.00 | 0.00 |
| | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,140,731,021.64** | **1,346,207,380.72** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 31,992,602,891.12 | 34,610,938,797.47 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 21,533,278.33 | 488,810,763.86 |
| | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **32,014,136,169.45** | **35,099,749,561.33** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,154,867,191.09** | **36,445,956,942.05** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 742,391,631.23 | 766,573,125.68 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.00 | 12,186.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 182,079,298.06 | 241,164,473.26 |
| 2.1.1.4 | НДШ–ийн өглөг | 243,120.00 | 84,040.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 85,438,055.11 | 13,593,529.50 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 0.00 | 1,443,671.58 |
| | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,010,152,104.40** | **1,022,871,026.02** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | 0.00 | 0.00 |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,010,152,104.40** | **1,022,871,026.02** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 33,981,526,313.42 | 33,981,526,313.42 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 0.00 | 3,155,701,953.17 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 0.00 | 462,450,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (1,836,811,226.73) | (2,176,592,350.56) |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **32,144,715,086.69** | **35,423,085,916.03** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **33,154,867,191.09** | **36,445,956,942.05** |

### 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | 4,074,715,928.76 | 5,077,397,920.50 |
| 2 | Борлуулалтын өртөг | 4,316,719,087.01 | 5,087,776,704.60 |
| **3** | **Нийт ашиг( алдагдал)** | (242,003,158.25) | (10,378,784.10) |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүгийн орлого | 274,931.39 | 249,258.17 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 268,790,600.34 | 37,328,806.70 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 1,794,942.55 | 12,768,287.90 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 77,110,386.42 | 67,085,593.09 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 178,063,354.11 | 159,531,906.15 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| **17** | Бусад ашиг ( алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | (229,906,309.60) | (212,186,506.37) |
| **19** | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | (229,906,309.60) | (212,186,506.37) |
| **21** | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | (229,906,309.60) | (212,186,506.37) |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 23.3 | Бусад олз (гарз) | | |
| **24** | **Орлогын нийт дүн** | (229,906,309.60) | (212,186,506.37) |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | - | - |

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **4,734,174,455.26** | **4,927,566,856.84** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 4,494,678,262.26 | 4,885,777,932.74 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 10,148,603.00 | 37,805,235.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 228,853,590.00 | - |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 494,000.00 | 3,983,689.10 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **4,612,731,559.68** | **4,784,320,092.27** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 780,836,803.00 | 1,059,130,389.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 309,456,780.65 | 392,786,094.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 1,673,398,071.36 | 1,573,123,000.43 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 518,909,527.20 | 599,932,513.00 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 976,393,489.19 | 680,835,757.00 |
| 1.2.6 | Хүүгийн төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 321,683,638.28 | 414,518,982.00 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 32,053,250.00 | 63,993,356.84 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **121,442,895.58** | **143,246,764.57** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **274,931.39** | **249,258.17** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 274,931.39 | 249,258.17 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **118,100,160.27** | **142,434,063.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 97,478,183.00 | 141,396,763.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 20,621,977.27 | 1,037,300.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(117,825,228.88)** | **(142,184,804.83)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | - | - |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | | |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | - | - |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |

| | | | |
|---|---|---|---|
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | | |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-** | **-** |
| **4** | Валютын ханшийн зөрүү | | |
| **5** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **3,617,666.70** | **1,061,959.74** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **17,099,700.58** | **20,717,367.28** |
| **7** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **20,717,367.28** | **21,779,327.02** |

### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2016 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **33,981,526,313.42** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **(1,600,734,214.73)** | **32,380,792,098.69** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | (6,170,703.00) | (6,170,703.00) |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 33,981,526,313.42 | - | - | - | - | - | (1,606,904,917.73) | 32,374,621,395.69 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | | | | | | | (229,906,309.00) | (229,906,309.00) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | | | | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | - |
| **9** | **2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **33,981,526,313.42** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **(1,836,811,226.73)** | **32,144,715,086.69** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | (127,594,617.46) | (127,594,617.46) |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 33,981,526,313.42 | - | - | - | - | - | (1,964,405,844.19) | 32,017,120,469.23 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | (212,186,506.37) | (212,186,506.37) |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | 462,450,000.00 | | 462,450,000.00 |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | | | | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | 3,155,701,953.17 | | | | 3,155,701,953.17 |
| **17** | **2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **33,981,526,313.42** | **-** | **-** | **3,155,701,953.17** | **-** | **462,450,000.00** | **(2,176,592,350.56)** | **35,423,085,916.03** |

### 4.5 Зорилтот түвшний биелэлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2017 оны гүйцэтгэл | 2018 он | | Харьцуулалт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | 2018 оны гүйцэтгэл | Төлөвлөгөөтэй | | Өмнөх оноос | |
| | | | | | | тоо | хувь | тоо | хувь |
| 1 | Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт | Гкал/жил | 64,551.20 | 61,000.00 | 73,425.20 | 12,425.20 | 120.37 | 8,874.00 | 113.75 |
| 2 | Дотоод хэрэгцээний ДЭХ,биет | Гкал/жил | 5,233.90 | 3,050.00 | 3,671.26 | 621.26 | 120.37 | (1,562.64) | 70.14 |
| | Дотоод хэрэгцээний ДЭХ,хувиар | % | 8.11 | 5.00 | 5.00 | - | 100.00 | (3.11) | 61.67 |
| 3 | Нийт орлого Үүнээс: | мян.төг | 4,343,506.40 | 4,991,056.40 | 5,114,976.00 | 123,919.60 | 102.48 | 771,469.60 | 117.76 |
| | Цэвэр борлуулалт | мян.төг | 4,074,715.80 | 4,957,285.30 | 5,077,397.90 | 120,112.60 | 102.42 | 1,002,682.10 | 124.61 |
| | Үйл ажиллагааны бус орлого | мян.төг | 268,790.60 | 33,771.10 | 37,578.10 | 3,807.00 | 111.27 | (231,212.50) | 13.98 |
| | Улсын татаасын орлого | мян.төг | - | - | - | - | | - | |
| 4 | Нийт зардал | мян.төг | 4,573,412.70 | 5,090,472.40 | 5,327,162.45 | 236,690.05 | 104.65 | 753,749.75 | 116.48 |
| | Үйл ажиллагааны зардал | мян.төг | 4,348,133.10 | 4,868,893.50 | 5,165,775.80 | 296,882.30 | 106.10 | 817,642.70 | 118.80 |
| | Үйл ажиллагааны бус зардал | мян.төг | 146,605.90 | 130,640.30 | 76,573.39 | (54,066.91) | 58.61 | (70,032.51) | 52.23 |
| | Удирдлагын зардал | мян.төг | 77,110.30 | 71,862.50 | 70,659.88 | (1,202.62) | 98.33 | (6,450.42) | 91.63 |
| 5 | Татварын өмнөх ашиг | мян.төг | (229,906.30) | (99,416.00) | (212,186.45) | (112,770.45) | 213.43 | 17,719.85 | 92.29 |
| 6 | Цэвэр ашиг | мян.төг | (229,906.30) | (99,416.00) | (212,186.45) | (112,770.45) | 213.43 | 17,719.85 | 92.29 |
| 7 | Төсвийн төлбөрт нийт дүн | мян.төг | 1,563.40 | 19,076.10 | 14,153.38 | (4,922.72) | 74.19 | 12,589.98 | 905.29 |
| | Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | мян.төг | - | 15,709.90 | 12,800.00 | (2,909.90) | 81.48 | 12,800.00 | |
| | АТӨЯХ-албан татвар | мян.төг | 263.40 | 599.90 | 457.10 | (142.80) | 76.20 | 193.70 | 173.54 |
| | Эдэлбэр газрын төлбөр | мян.төг | - | 1,466.30 | - | (1,466.30) | - | - | |
| | Ус ашигласаны төлбөр | мян.төг | 1,300.00 | 1,300.00 | 896.28 | (403.72) | 68.94 | (403.72) | 68.94 |
| | Бусад татвар | мян.төг | - | - | 0.00 | 0.00 | | 0.00 | |
| 8 | Төрийн өмчийн ногдол ашигт | мян.төг | - | - | - | - | | - | |
| 9 | Нийт ажиллагсадын тоо | хүн | 133.00 | 147.00 | 153.00 | 6.00 | 104.08 | 20.00 | 115.04 |
| 10 | Нийт цалингийн сан | мян.төг | 1,129,985.50 | 1,554,004.40 | 1,541,099.10 | (12,905.30) | 99.17 | 411,113.60 | 136.38 |
| 11 | Нэг ажиллагчийн дундаж цалин | төг | | | | - | | - | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Нэгж бүтээгдэхүүний өртөг | төг | 70,849.38 | 83,450.37 | 72,552.24 | (10,898.13) | 86.94 | 1,702.85 | 102.40 |
| 13 | Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал | төг | 1.05 | 1.02 | 1.04 | 0.02 | 102.11 | (0.01) | 98.91 |
| 14 | Нийт авлага | мян.төг | 157,146.50 | 100,000.00 | 774,310.60 | 674,310.60 | 774.31 | 617,164.10 | 492.73 |
| 15 | Нийт өр төлбөр | мян.төг | 1,010,152.10 | 500,000.00 | 1,022,871.02 | 522,871.02 | 204.57 | 12,718.92 | 101.26 |
| 16 | Хөрөнгө оруулалт | мян.төг | 33,128.50 | 1,276,744.80 | 281,848.98 | (994,895.82) | 22.08 | 248,720.48 | 850.77 |
| | үүнээс: өөрийн хөрөнгөөр | мян.төг | 33,128.50 | 1,276,744.80 | 281,848.98 | (994,895.82) | 22.08 | 248,720.48 | 850.77 |
| 17 | Байгаль орчны шинэчлэл | мян.төг | - | 6,248.00 | 1,061.70 | (5,186.30) | 16.99 | 1,061.70 | |

# 5 Аудитын явцад илэрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

( төгрөгөөр)

| Огноо : | 2018.12.31 | Аудитын нэр: | 2018 оны санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: | САГ-2019/118/СТА-ТӨХК |
|---|---|---|---|---|---|
| Шалгагдсан байгууллагын нэр: | “Хөвсгөл дулааны станц” ТӨХК | сая төгрөгөөр | | | |

| № | Аудитын чиглэл | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллага ас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | | 3 | 4.0 | 5 | 9 | 10 |
| 1 | Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа | Мөрөн сумын орон нутгийн төсвийн 32 байгууллагад хүчингүй болсон тарифаар дулаан нийлүүлэх гэрээ хийж, нийт 977.9 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан, энэ үйл ажиллагаатай холбоотой 659.5 сая төгрөгийн хэрэгжээгүй борлуулалт, авлагыг нөхөн бүртгэсэн | 977.9 | Албан шаардлага өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 2 | Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа | “Дулаан-Орд” ХХК-тай байгуулсан ажлын байрны зориулалтаар ус, дулаан дамжуулах төв түрээслүүлэх гэрээгээр түрээслэгч тус төвөөр дамжуулан борлуулсан дулааны орлогын 70.0 хувь, дулаан дамжуулах төвд гарсан зардал, төвийн нэг ажилтаны цалин 384.0 мянган төгрөгийг сар бүр түрээслэгч хариуцна гэж илт ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулсан | - | Албан шаардлага өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 3 | Өглөгтэй холбоотой асуудал | Харилцагч 9 байгууллагатай 137,986.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, актаар баталгаажсан "Абдикс" ХХК-ийн өглөгийг 1,453.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 139.4 | Албан шаардлага өгөх | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Балансын данстай холбоотой асуудал | 69,487.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө өөр байгууллагад давхар бүртгэлтэй | 69.5 | Албан шаардлага өгөх | | |
| 5 | Дотоод хяналттай холбоотой асуудал | Компанийн өмнөх гүйцэтгэх захирал ТУЗ болон ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр өөртөө 1,417.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, 170.0 мянган төгрөгийн ажил олгогчийн НДШ төлсөн | 1.6 | Акт тавих | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 6 | Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал | Кассын зарлагын баримтад мөнгө хүлээн авагчаар гарын үсэг зуруулдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ бүртгэсэн | - | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 7 | Үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал | 1. Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын чанартай зүйлс, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн чанартай зүйлс бүртгэсэн 2. Дуусаагүй барилга дансыг бараа материалд бүртгэж тайлагнасан | 47.9 | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 8 | Үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал | Хөрөнгийн тооллого, тооцоо бодолтыг чанартай хийдэггүйгээс | - | Зөвлөмж өгөх | | |
| 9 | Үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой асуудал | Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоонд Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ыг мөрдөөгүй, хөрөнгийн ашиглах хугацааг 1-55 жилийн зөрүүтэй тооцсон | - | Зөвлөмж өгөх | | |
| 10 | Эздийн | Төрийн өмч санхүүгийн | | Зөвлөмж | Гүйцэтгэх | Ч.Цогоо, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | өмчтэй холбоотой асуудал | тайланд 33,981,526.3 мянга, улсын бүртгэлийн гэрчилгээнд 26,008,174.1 мянга, компанийн дүрэмд 32,380,792.0 мянган төгрөг гэж тус тус зөрүүтэй байна. | - | өгөх | захирал, Ерөнхий нягтлан бодогч | В.Мөнгөнцэцэг |
| 11 | Худалдан авалттай холбоотой асуудал | Тайлант оны нүүрс, шатах тослох материал, тээвэрлэлтийн худалдан авалтыг нийлүүлэгч байгууллагуудаас татварын цахим системд 9,465.8 мянган төгрөгөөр илүү бүртгэснээс үндэслэлгүйгээр НӨАТ-аас хасалт хийсэн, 61,056.6 мянган төгрөг дутуу бүртгэснээс НӨАТ-ын өглөгөөс хасалт хийх боломжыг алдсан | 70.6 | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 12 | Зардалтай холбоотой асуудал | Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулсан нүүрсний зарцуулалт инженерийн албаны тооцоогоор 24,238.0 тн, эдийн засагчийн тооцоогоор 24,140.0 тн, санхүүгийн тайлангаар 24,250.0 тн гэж тус тус зөрүүтэй тайлагнасан | - | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| 13 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. | - | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Ч.Цогоо, В.Мөнгөнцэцэг |
| | | | **1,306.8** | | | |

# ТЭМДЭГЛЭЛ